

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

Tom. XXXI (328)

2010

248-253

## ХҮҮХДИЙН ЯРУУ НАЙРГИЙН ХЭМ ХЭМНЭЛИЙН ТУХАЙД

Д.Батжаргал<sup>1</sup>

Сонсоход хөгжимлөг, яруу сонсголонтой алхаа гишгээ мэт айзам хэмнэлтэй шүлэг дэлхийн аль ч үндэстний утга зохиолд нийтлэг байдаг. Тэр тусмаа хүүхдийн шүлгүүд айзам хэмнэлтэй байх нь тэдний хэл ярианд тохирсон, уншихад эвтэй, өмнө нь цээжилсэн хүүхэд нэг мөрийг нь олохоор нөгөө мөрүүд нь аяндаа нэхэгдэх жишээтэй. Америкийн зохиолч Жон Чиардийн “Малгайгүй хүн” шүлэг нь

*Замын гарцны  
Цаахантай  
Эмийн сангийн  
Наахантай  
Танихгүй хүнтэй  
Таарлаа би.  
Малгайгүй түүнтэй  
Уулзлаа би...* гэж эхэлдэг.

“Замын гарцны”, “Эмийн сангийн” гэх мэт байршил заасан үгсийг улам тодотгож, “наахантай”, “цаахантай” гэсэн үгс хөгжим хэмнэл үүсгэж “танихгүй хүнтэй”, “малгайгүй түүнтэй” гэх мэт нь хачирхал, сонирхол төрүүлж байна. Тэр бүхэн дээр санаагаа давтан “таарлаа би”, “уулзлаа би” гэж өчиж байна.

АНУ-ын эрдэмтэн, утга зохиолын онолч Рене Уэллек, Остин Уоррен нар “Утга зохиолын онол” номондоо “Англи хэлэнд эр хэмнэл давамгайлдаг. Английн яруу найрагчид эм ба гурван үет хэмнэлийг зохиолоо хошин өнгө аястай болгоход ашиглаж иржээ. Харин дундад зууны латин хэл, итали, польш хэлний хувьд эм хэмнэлийг ёс мэт нэлээд гүнзгий агуулгатай хам сэдэвт ашигласаар иржээ”<sup>2</sup> гэж бичсэн байна.

Мөн зохиолч Карл Сэндберг “Үгээ бод охин минь” шүлэгтээ,

*Болчимгүй үг хэлэхээс л  
Болгоомжил охин минь!  
Аливаа хэлсэн үг гэдэг  
Аманаас гарсан хий боловч  
Ариун сэтгэлийн хуудаснаа  
Ашид бичигдэн үлддэг билээ.  
Үг-Голын уснаас шингэн  
Үг-Галын дөлнөөс хөнгөн  
Үг-Сарны гэрлээс тунгалаг*

<sup>1</sup> МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль

<sup>2</sup> Rene Wellek and Austin Warren “Theory of literature” УБ 1998

**Үг-Сарнай цэцгээс өнгөлөг**

**Үг-Хад чулуу шиг хүнд**

**Үг-Ган төмөр шиг бөх**

**Үг-Алт адил үнэтэй**

**Үг-Амьтан адил амьтай.**

**Бодолгүй хэлсэн ганихан уг**

**Тагтааны өндөгнөөс ч хэврэг**

**Болгоомжтой ярьж байгаарай,**

**Танхил эсаахан охин минь!**

**Ахмад хүнтэй мэндлэн золгоходоо ч**

**Анд найзтайгаа хошигнон ярихдаа ч**

**Аль эсвэл хүслээ нээхдээ ч**

**Амнаас гарах үгээ цэгнэ!**

Хэдийвээр сургамжлаад байгаа боловч, хийсвэр ухагдахууныг хүүхдүүд мэдэх байгалийн үзэгдэл, биеттэй харьцуулж дүрсэлсэн нь тэдэнд аливаа зүйлийг бодогдуулах, санагдуулахыг хичээсэн нь сайн талтай. Хэмнэлийн хувьд аваад үзвэл эхлэл төгсгөл хоёрт нь найм найман мөрөөр хашиж дунд “үг” хэмээх хийсвэр утга нь “хөнгөн шингэн”, “тунгалаг өнгөлөг”, “хүнд бөх”, “үнэтэй, амьтай” зэрэг хоршоо үгсээр ижилсүүлэн сүүл холбожээ.

Улс үндэстэн бүрийн хэл яриа өөр болохоор шүлэглэх журам дэг маяг нь ч өөр өөр байдаг. Ялангуяа дорно дахины тансаг шүлэгт бүр ч их байдаг нь ойлгомжтой. Японы хүүхдийн зохиолчийн ńэгэн шүлгийг жишээ ажиглахад сонин хэмнэл харагдаж байна. Хүүхдүүд амрахаар орондоо ордог ч гадна зөндөө зүйл амарч чадахгүй үлдэг гэдэг санааг ирж буй “айлчин” мэтээр дүрсэлсэн байна. Тэр нь зориуд “тог тог тог” хийсэн чимээ өгч хүүхдийн анхаарал төвлөрүүлж байна. Китахара Хакусю “Сартай шөнөөр”

**Тог... тог... тог**

**-Хаалгаа нээ**

**-Альхан газрын хэн нь**

**Аяар аяархан тогшино вэ?**

**-Агч модны навчхан би**

**Аядуу намдуу тогшиж байна**

**Тог... тог... тог**

**-Хаалгаа нээ**

**-Цаана нь чухам хэн**

**Чанга чанга тогшино вэ?**

**-Уулын хучит салхи би**

**Үуртай ширүүн тогшиж байна**

**Тог... тог... тог**

**-Хаалгаа нээ**

**-Одоо бас хэн нь**

**Орой хожуу тогшино вэ?**

**-Алиман сарны туяа би**

**Аажсуу ирээд тогшиж байна.**

Хүмүүс амарч байх үед сахиул манаач нар, магадгүй аюулт өвчинтэй тэмцдэг шөнийн ээлжийн эмч нар, амгалан тайван байдлыг хангахын төлөө цагдаа нар салхи сарны туян дор гадаа үлддэг гэсэн давхар санаа бууж байна. Тог тог тог гэсэн тогшилт хүүхдэд уттыг сануулах давхар дохио гэлтэй.

Монгол шүлэг бол өргөлтийн шүлэг юм. Энэ талаар эрдэмтэн Д.Цэнд “Монголчууд шүлгийнхээ айзам хэмжээг жигд нарийн болгох гэж аялан уншиж, хөгжмийн хөг аялгуунд нийлүүлэх, тэмээ малын алхаа гишгээнд тохируулах зэрэг айзамт нэгжийн олон талын аргыг сувэгчлэн боловсруулсан учир манай шүлэг бол маш нарийн хийцтэй аялан уншихад тохирсон нэгэн зүйлийн хөгжимт шүлэг болсон ажээ.

Яруу найрагч Д.Сэнгээгийн “Цолмон” шүлэг үг хэлээр төдийгүй, өөрийн хэмнэлээр хурдан морины уралдааны харуулсан бол төрийн шагналт яруу найрагч Д.Нямаагийн “Тэмээний уралдаан” шүлэг телевизийн сурвалжлага мэт гурван планаар уншигчдын сонирхол татаж байдаг. Энэ шүлэг аль насны хүмүүст сонирхолтой.

*Тэмээ тэмээнийхээ араас*

*Тэшин тэшин гарав*

*Тэгшхэн талын зоон дээр*

*Нисэн нисэн хурдлав*

*Дөрөөн тавхай нь*

*Яралзан яралзан хурдлав*

*Дөрөөн сэнж нь*

*Гялалзан гялалзан хурдлав...*

Хүүхдийн яруу найргийн бүтээл энгийн үгтэй, хэл найруулгын сонгодог арга хэлбэрээр бичигдсэн байхаас гадна хөдөлгөөнтэй, хөгжимлөг, хэм хэмнэлтэй агуулгаа илүү сайн гаргах нь ойлгомжтой. Монгол хүүхэд хөдөө нутагтаа хөх тэнгэр, хөрст дэлхий, од нар сараар тоглож өсдөг. Үүнийг монгол найрагчид олонтаа баархан бичсэн нь бий.

Академич Ц.Дамдинсүрэн “Шүлгийг зохиох ба засахад утгаас гадна бас шүлгийн хэмжээ уншигдах аялгууг гол болгоно. Мөрийн доторх дуунуудыг журамтайгаар тэнцүүлбэл зохино. Шүлэгт хэлж байгаа үсийг хэсэг хэсгээр хувааж, богиновтор мөр болгоно. Мөрийн доторхи дуунуудыг журамтайгаар тэнцүүлвэл зохино” гэж бичжээ. Хэмнэлтэй бичдэг хүүхдийн яруу найргийн нэг төлөөлөгч нь хүүхдийн зохиолч Ж.Дашдондог юм. Тэрбээр хэм хэмнэл сайтай шүлгүүдээ уулзалт цуглаан дээр өөрөө унших ихээхэн дуртай. Бусад хүн уншихаар тэр хэмнэлийг нь сайн гаргаж ирдэггүй байж болох юм.

Бид олон удаа хамт явж уулзалт ярилцлагад оролцсон болохоор яаж уншиж, яаж жүжиглэдгийг нь сайн мэднэ. Хүүхдүүдтэй уулзалт хийх бүрдээ унших дуртай “Үхэр тэрэг” шүлгийг аялгуулан уншихдаа “Үхэр тэрэг үг хэлнэ, дугуйт тэрэг, дуу аялна...”<sup>3</sup> гэдгийг ердийн байдлаар уншиж байснаа,

*Даваа даваа*

*Эгцэрлээ*

*Ачаа, ачаа*

*Хүндэрлээ*

Ачаа, даваа гэдэг төсөөт хоёр үгээр холбож, эгцэрлээ, хүндэрлээ гэсэн үйлийг заасан төсөөтэй хоёр үг нь сөөлжүүлсэн холболтыг үүсгэж байна. Дараагийн бадагт зураглал

<sup>3</sup> Ж.Дашдондог “Зуун хурга” УБ 1979 тал 29

гаргаж амбан шар хэрхэн зүтгэж тэрэг хэрхэн гаслан дуулж байгааг үнэмшилтэй гаргажээ.

*Амбан шар*

*Хүзүү сунгана*

*Аралтай тэрэг*

*Гаслан дуулна*

*Тос – лоо – од одөөч!*

*Тус – лаа –aad одөөч!*

Хүүхдийн зохиолч жүжигчин лугаа адил шүлгээ уран тод жүжиглэлтэй унших гэсэн хэсэг дээр өөрөө ачаа чирч яваа мэт үгээ зөөн нүүр амаа үрчийлгэн чүй ай даваан дээр “тарч ирдэг” бол,

*Даваан дээр*

*Гарлаа, гарлаа*

*Давааны цаад руу*

*Орлоо орлоо*

*Амбан шар*

*Бөмбөрөн шогшино*

*Аралтай тэрэг*

*Баясан дуулна.*

*Тостай ч яахав*

*Тосгүй ч яахав*

*Тустай ч яахав*

*Тусгүй ч яахав*

гэсэн төгсгөл хэсэгтээ их ажил амжуулсан мэт хөөр баяртай болж зохиолч хоёр тийш ганхан өөрөө даваа уруу уруудаж яваа мэт хэмнэлд нь тааруулан уншдаг. Хүүхдүүд үүнд нь дуртай байдаг.

Энэ талаар японы хүүхдийн нэért зохиолч Миёоко Мацутани “Хэдэн жилийн өмнө монгол зохиолч Дашибондог Токиод айлчлахдаа манай гэрт ирж билээ. Тэгэхэд манай хашаан дахь “Ном ба хүүхэлдэйн гэр” хэмээх байшинд хүүхдүүд цугларч таарсан. Дашибондог тэдэнд шүлгээ уншихдаа хэмнэлийнх нь дагуу хөдөлгөөн оруулан бараг л бүжиглэж байна уу даа гэмэр байлаа. Тэнд цугларсан хүүхдүүдийн болон миний сэтгэлд нэг л баясгалант бөгөөд дулаахан аялгуу урсаад орж ирэх шиг болсон. Японы зохиолчдод тэр бүр байдаггүй уран уншлагын гайхамшигийг Дашибондог бидэнд үзүүлсэн бөгөөд бид ч мэл гайхаж, ямар сайхан юм бэ? гэхээс өөрийг хэлж чадахгүй байлаа” гэж хэлсэн байдаг.

“Үхэр тэрэг” шүлэг донжтой гоё уран санаагүй мөртлөө хэмнэлээрээ хүүхэд багачуудын татсан уран уншлагад зориулсан шүлэг юм. Хэрвээ зохиолч уран санаа олсон болсон шилдэг бүтээл болох байлаа.

“Ж.Дашибондог “Аав, ээж, би” номноосоо хойш тэрөл арилжсан мэт өөрчлөгдөж өөрийн өвөрмөц хоолойгоо олж чадсанaa удаа дараа баталсаар ирсэн юм. Ялангуяа Хөвсгөлийн алдарт улаан тайгаар цаа буга унан аялж яваад бичсэн “Ар тайгын хүү” номноос нь түүний өвөрмөц дуу аялгуу улам ч тод сонсогддог. Энэ номондоо байгалийн аялгуу амьдралын хэмнэлийг үгийн эгшгээр гайхамшигтай сайхан дүрсэлж, хүүхдийн уран зохиолд хийсэн шинэчлэлээ хөгжимлөг шүлгээрээ улам гүнзгийрүүлсэн байдаг. Эдгээр шүлгээс цасан дундуур цар цар хийх цаа бугын туурай, шаагин

бөмбөрөх мөндрийн чимээ, шуурганд бөхөлзсөн моддын шивнээ сонсогдох шиг болж байна”<sup>4</sup>.

*...Тайгын нуруунд бөмбөрсөн  
Танан цагаан мөндөр сөн  
Цааны нуруунд бөмбөрсөн  
Цалин цагаан мөндөр сөн  
Усан дээгүүр бөмбөрсөн  
Уран цагаан мөндөр сөн  
Урцан дээгүүр бөмбөрсөн*

*Шүрэн цагаан мөндөр сөн...* /”Аранзал зээрд” ном 1993 он. 93

дугаар тал/ Нээрээ ч Норико хатагтайн өгүүлсэн шиг “сөн” гэсэн төгсгөлүүд нь хөгжимлөг өнгө аясыг илэрхийлээд зогсохгүй тайгад элбэг орж хaa сайгүй “бөмбөрч” байdag мөндөрийн ширхгүүд нүднээ үзэгдэх мэт болно.

*Зайвар голцуу  
Зайвар голцуу тайгаар нь  
Зарийн цэрций  
Зарийн цэрций шаагиулна  
Заач л тойруу  
Заач л тойруу хангайгаар  
Замттай замгүй  
Замттай замгүй жийгүүлиэ.../“Цааны алхаа” 87 дүгээр тал/*

“Ар тайгын хүү” номын шүлгүүд хэллэг, дурслэл сайтай болсныг доктор Д.Болд<sup>5</sup>, Ч.Арьяасүрэн, төрийн соёрхолт зохиолч Д.Гармаа нар дүгнэсэн байна.

Хүүхдүүдийн хамгийн ойр дотны найз нар, хамтран туслагчид сургууль түүний орчныхон юм. Сургуульд зөвхөн багш, найз нар, тэгэхэндээ тэнгийнхнээс гадна жижүүр, цэвэрлэгч, эмч, гуанзы тогооч хүүхдэд ойр томчууд зөндөө бий. Тэдний нэг нь сургуулийн цэвэрлэгч яах аргагүй мөн. Энэ тухай манай зохиолчид олонтаа бичсэн. Тэдний дундаас Дащдондогийн “Сургуулийн цэвэрлэгч” үгээрээ төдийгүй шүлгийн хэмнэл давтамжаараа цэвэрлэгчийг бас илэрхийлж байна.

*...Хаясан цаасыг  
Хамаад л  
Ханын тоосыг  
Гөвөөд л  
Шалны алчуур  
Норгоод л  
Шатны гишгүүр  
Арчаад л...*<sup>6</sup>

“Ж.Дашдондогийн бүтээлийг уншихад ухаалаг монгол хүүхдүүд харагддаг. Монгол хүүхдүүдийн гүйж харайж, инээж хөгжилдөж явааг үзэхэд түүний шүлэг санагддаг. Үг, мөр, бадаг бүр нь хүүхэд шиг хөдөлгөөнтэй, хүүхэд шиг цовоо, их хөгжимлөг байдаг. “Та нар Дащдондог шиг шүлэг бичээч! Хүүхдүүд нэг уншаад л цээжилчих юм байна

<sup>4</sup> Цуда Норико “Жамбын Дащдондог” УБ 2005 тал 13

<sup>5</sup> “Хүүхдийн хүмүүжил” сэтгүүл 1972.<sup>1</sup> 6 тал 44-46

<sup>6</sup> Ж.Дашдондог “Шүлгийн морь” 1986 он тал 37

шүү дээ” гэж цэцэрлэгийн багш, эцэг эхчүүд ярьж байхыг олонтаа сонссон<sup>7</sup> гэж Нацагдоржийн шагналт зохиолч С.Надмид өгүүлсэн байдаг. Энэ мэт үнэлгээг олон зохиолч хэлж чадна.

Түүний бүтээлийн хэмнэл, гишгэцийг ажиглаад байхад “Хүүхэд харагдаж”, “Тайгын өнгө төрх, зун орсон мөндрийн ширхэг сонсогдож”, “Хоёр тийш хайвагнасан цайны алхаа”, “Нэг ажлаа давтан давтан хийж байдаг сургуулийн цэвэрлэгчийн нүсэр хөдөлмөр үзэгдэж” байна. Ертөнцийг чимээ дуутай нээнэ гэдэг хүүхдийн зохиолчид л байх ёстой нандин зүйлийн нэг билээ. Судлаач Д.Өлзийбаяр “...ойролцоо дуудлагатай үт, үг давталт зэргийг оновчтой хэрэглэснээрээ шүлгүүд нь хэмнэл хэмжээ жигдхэн болдгоос хүүхдийн сэтгэхүйн онцлогт нэн тохирдог байна”<sup>8</sup> гэж дүгнэсэн байна.

Ж.Дашдондогийн “Дээл” /“Зуун хурга” 1979 он/ шулэгт шинэ дээлээ урсан хүү оёдолчинд очоод оёж өгөөч гэхэд хоньчноос ноос авчир гэдэг. Хоньчин нь өвс, хадланчин нь хадуур, төмөрчин нь нүүрс, уурхайчин нь талх, талхчин нь гурил, тээрэмчин нь тария, тариачин нь шулэг хэрэгтэй гээд зохиолчид ирсэн тухайгаа хэлдэг. Ардын үлгэрийн дамжих холбоосыг ашигласан энэхүү шулэг зохиомжийн хувьд сонин юм. Дамжих холбоос нь дахин дахин давтагдаж царцаа найзыгаа голоос аврах гэж уйгагүй явдаг шоргоолжны үлгэрийг санагдуулж байгаа нь бас нэг төрлийн хэмнэл юм.

Үүнээс үүдээд хэлэхэд хүүхдийн яруу найргийн хэмнэл гэдэг зөвхөн морь малын алхаа гишгээнд тохирсон хөгжимлөг байхаас гадна нэг шүлгэнд хэд хэдэн янзаар ч байж болох уянга юм. Тэгэхээр дагнасан эсвэл холимог шинжтэй хэмнэл байх нь ерийн үзэгдэл билээ.

## Ном зүй

1. Дашдондог. Ж “Зуун хурга” УБ 1979 он
2. Дашдондог. Ж “Аранзал зээрд” УБ 1993 он
3. Дашдондог. Ж “Шүлгийн морь” УБ 1986
4. Rene Wellek and Austin Warren “Theory of literature” УБ 1998
5. “Утга зохиол” сонин 1992 № 13
6. “Утга зохиол” сонин, 1996<sup>1</sup> 8,9
7. “Хүүхдийн хүмүүжил” сэтгүүл 1972.<sup>1</sup> 6
8. Цуда Норико “Жамбын Дашдондог” УБ 2005

## SUMMARY

Rhythm in children poetry is not only melodious like movement of horse and cattle but also harmonious that could be found in different ways in a poem. Therefore, it is common to be single or mixed rhythm.

<sup>7</sup> “Утга зохиол” сонин 1996<sup>1</sup> 8,9 “Шүлгэн өргөө” өгүүлэл

<sup>8</sup> “Утга зохиол” сонин 1992<sup>1</sup> 13 “Алтан унаганы үлгэр”